



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 424

Улаанбаатар хот

Хорт хавдраас сэргийлэх, хянах
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа – 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа" – ны 9.1.11 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр (2025-2028) – ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа), Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв (М.Адилсайхан)-д тус тус үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэрт зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Хавдар судлалын үндэсний төв (М.Адилсайхан)-д ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа), Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт тус тус ирүүлэхийг Хавдар судлалын үндэсний төв (М.Адилсайхан)-д даалгасугай.

141251376

6. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, хамтын ажиллагаатай улс орон болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг хэрэгжүүлэгч байгууллагын дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

7. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
...06 сарын 22-ны өдрийн
...дүгээр тушаалын хавсралт

291



ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ХӨТӨЛБӨР

2025-2028 он

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АГУУЛГА.....	2
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	3
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	3
НЭГ. ҮНДЭСЛЭЛ.....	6
1.1 ХОРТ ХАВДРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ ДЭЛХИЙ ДАХИНАА	6
1.2 ХОРТ ХАВДРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ МАНАЙ УЛСАД	6
1.3 Хавдраас сэргийлэх, хянах дэлхий дахины бодлого	8
1.4 Хавдраас сэргийлэх, хянах бодлого, хэрэгжилт манай улсад	9
ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТ	11
2.1 Алсын хараа:	11
2.2 Зорилго:	11
2.3 Зорилт:.....	11
2.4 Хэрэгжүүлэх зарчим:.....	11
ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ	12
3.1 Зорилт 1. Хүн амын дунд хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг идэвхжүүлэх.	12
3.2 Зорилт 2. Хорт хавдрын эрт илрүүлэгт зорилтот бүлгийн хүн амын 50-с доошгүй хувийг хамруулж, эрт оношилгоог өргөжүүлэх.....	13
3.3 Зорилт 3. Тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулан хорт хавдрын оношилгоо, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.....	14
3.4 Зорилт 4. Хорт хавдрын үеийн сэргээн засах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.....	16
3.5 Зорилт 5. Хорт хавдрын бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрэн цахимжуулж эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх.....	17
3.6 Зорилт 6. Хорт хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлж буй хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх.....	18
ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	20
4.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	20
4.2 Хөтөлбөрийн санхүүжилт:	21
4.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хяналт- шинжилгээ үнэлгээ:.....	21
ТАВ. ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ.....	23
5.1 ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ.....	23
5.2 ХОДООД, УЛААН ХООЛОЙН ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ	24

5.3	БҮДҮҮН, ШУЛУУН ГЭДЭСНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ	25
5.4	УУШИГНЫ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ.....	26
5.5	УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ.....	27
5.6	ХӨХНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ	28
	ЗУРГАА. ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	29
6.1.	ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028)	29
6.2.	НЭГ. ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	38
6.3.	ХОЁР. УЛААН ХООЛОЙ, ХОДООД, БҮДҮҮН-ШУЛУУН ГЭДЭСНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	44
6.4.	ГУРАВ. УУШГИНЫ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	49
6.5.	ДӨРӨВ. УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	52
6.6.	ТАВ. ХӨХНИЙ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	56
6.7.	ЗУРГАА. ЦУСНЫ ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	58
6.8.	ДОЛОО. ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	60

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР
АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
АФП	Альфа-фетопротейн
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
БГДНЭ	Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэг
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
КТГ	Компьютер томографи
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХПВ	Хүний папиллома вирус
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХУДНЭ	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг
СХДНЭ	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг
ЦДШ	Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭСҮТ	Эмгэг судлалын үндэсний төв
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭЭХХЗГ	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
IMRT – intensity modulated radiation therapy	Эрчмийг тохируулах туяа эмчилгээ
VMAT- volumetric modulated arc therapy	Эзэлхүүнт нуман туяа эмчилгээ
SBRT- stereotactic body radiation therapy	Стереотактик биеийн туяа эмчилгээг

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

1.1 ХОРТ ХАВДРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ ДЭЛХИЙ ДАХИНАА

Дэлхийн хүн амын нас баралтын 70 гаруй хувийг хүний амьдралын хэв маягаас шалтгаалсан халдварт бус өвчин эзэлж, жилдээ 15 гаруй сая хүн халдварт бус өвчний улмаас нас барж байгаагаас 4,5 сая тохиолдлыг хорт хавдрын шалтгаант нас баралт эзэлж байна. Халдварт бус өвчнөөс шалтгаалсан цаг бусын нас баралтын 30 хувийг 30-69 насны хүн амын дундах хорт хавдар дангаар эзэлж байна.

Хавдрын судалгааны олон улсын агентлагийн статистик мэдээллээр 2022 онд 20 сая гаруй хүн хорт хавдраар өвдөж, 9.7 сая хүн хорт хавдрын шалтгаанаар нас барсан байна. Хорт хавдрын өвчлөл, нас баралтын хувьд уушгины хорт хавдар тэргүүлж, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар, ходоодны хавдар удаалсан байна.


Хүн амын дундах эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, түүнийг бууруулах оновчтой арга хэмжээг хэрэгжүүлснээр хорт хавдрын өвчлөлийн 50 хүртэлх хувийг урьдчилан сэргийлэх боломжтой хэмээн ДЭМБ-аас улс орнуудад зөвлөмж болгосон. Тухайлбал, уушгины хорт хавдрын хамгийн том эрсдэлт хүчин зүйл болох тамхины эсрэг арга хэмжээг оновчтой, тууштай хэрэгжүүлснээр 20-30 жилийн дараа уушгины хавдрын өвчлөл, нас баралтыг зарим улс орнууд эрс бууруулж чадсан. Өндөр хөгжилтэй орнууд сүүлийн 30 жилийн хугацаанд хорт хавдар үүсгэгч вирусийн халдварын эсрэг хариу арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр элэг, ходоод, умайн хүзүүний хорт хавдар эрс буурч байгаа ч бага орлоготой, буурай хөгжилтэй орнуудад хорт хавдрын нас баралт жилээс жилд нэмэгдэх хандлагатай байна.

1.2 ХОРТ ХАВДРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ МАНАЙ УЛСАД

Монгол Улсад жилд дунджаар 6,000 гаруй хорт хавдар шинээр бүртгэгдэж, 4,000 гаруй хорт хавдартай иргэн нас барж байна. Дэлхийн бусад улс оронтой харьцуулахад манай улс хорт хавдрын өвчлөлийн түвшнээр эхний 50 орны тоонд багтаж, хавдрын шалтгаант нас баралтын эрэмбээр дэлхийд тэргүүлж байна.

Хорт хавдрын өвчлөл жилээс жилд өсөх хандлагатай байгаа ба 100 000 хүн амд ногдох өвчлөлийн түвшин 2004 онтой харьцуулахад 1.4 дахин нэмэгдэж, нас баралтын түвшин 2019 оноос хойш ялимгүй буурах хандлага ажиглагдаж байна.

Хорт хавдрын өвчлөл, нас баралтын түвшин, 100 000 хүн амд, 2004-2024 он




Нийт өвчлөлийн дийлэнх хувийг эрэгтэйчүүд эзэлж, 3 эрэгтэй тутмын 1 нь хорт хавдраар өвчилж байна. Мөн 75 хүртэлх насны нийт хүн амын хорт хавдраар өвчлөх эрсдэл 28.4 хувь (эрэгтэй 35.6 хувь, эмэгтэй 23.4 хувь) байна.

Сүүлийн 10 жилд хүн амын дундах хорт хавдрын өвчлөл, нас баралтад элэгний хорт хавдар 36 хувь, ходоодны хорт хавдар 15 хувь, уушгины хорт хавдар 8 хувь, умайн хүзүүний хорт хавдар 7 хувь, улаан хоолойн хорт хавдар 6 хувь, хөх болон бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар тус бүр 4 хувийг эзэлж байна.

Булган аймаг бусад аймгуудтай харьцуулахад өвчлөлийн түвшнээр хамгийн өндөр буюу 100 000 хүн амд 379.8, Баян-Өлгий аймаг хамгийн бага буюу 100 000 хүн амд 154.1 байна.

Хорт хавдрын өвчлөлийн түвшин 100 000 хүн амд, аймаг, бүсээр, 2023 он



2023 онд бүртгэгдсэн хорт хавдрын шинэ тохиолдлыг 2019 онтой харьцуулахад хожуу үе шатандаа оношлогдох тохиолдол 7 хувиар буурч 65 хувь болсон эерэг үзүүлэлт гарсан ч бусад улс оронтой харьцуулахад эрт оношилгооны хувь бага хэвээр байна.

Сүүлийн 5 жилийн дунджаар нийт хорт хавдрын 29.4 хувь нь эрт үедээ, 70.6 хувь нь хожуу үе шатандаа оношлогдож байна. Тухайлбал, уушгины хорт хавдрын 90 хувь, улаан хоолойн хорт хавдрын 80 хувь, ходоодны хорт хавдрын 75 хувь, бүдүүн, шулуун гэдэсний хавдрын 78 хувь нь хожуу үе шатандаа оношлогдсон байна.

Монгол Улсын Засгийн газраас хорт хавдрын эрт илрүүлгийн хөтөлбөрийг 2012 оноос эхлэн хэрэгжүүлсний үр дүнд хөхний хорт хавдрын 58 хувь, умайн хүзүүний хорт хавдрын 53 хувь нь эрт үедээ оношлогдсон эерэг үзүүлэлт гарчээ.

Харин 2023 оны байдлаар хорт хавдар анх оношлогдон, хяналтад орж тусламж, үйлчилгээ авснаас хойш 1 хүртэлх жил амьдарсан хорт хавдартай иргэд 14 хувь, 1-3 жилийн хугацаанд амьдарсан иргэн 21 хувь, 4-5 жилийн хугацаанд амьдарч байгаа иргэд 16 хувь, 5-аас дээш жил амьдарч байгаа иргэд 49 хувийг эзэлж байна.

Хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх чухал шалгуур үзүүлэлтийн нэг нь хорт хавдар оношлогдсоноос хойш 5 болон түүнээс дээш жил амьдарсан хугацаа бөгөөд сүүлийн 10 жилийн хугацаанд энэхүү үзүүлэлт

14 хувиар өсөж, 2023 оны байдлаар 43 хувьд хүрсэн хэдий ч дэлхийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад доогуур хэвээр байна.

Хүүхдийн хорт хавдрын нөхцөл байдал

Дэлхий дахинд жилд 400,000,000 орчим хүүхэд хорт хавдраар өвддөг. Өндөр хөгжилтэй оронд хүүхдийн хорт хавдрын эдгэрэлтийн хувь 80%-иас дээш байдаг бол, бага дунд орлоготой оронд 30%-иас доош байдаг. Энэ эрс ялгаатай байдал нь хүүхдийн хавдрын оношилгоо, эмчилгээний тэгш бус хүртээмж, хавдрын эмийн чанар, зах зээлийн олдоц, боломж цаашлаад тусламж үйлчилгээ үзүүлж буй хүний нөөцийн хүчин чадал зэрэгтэй холбоотой. Манай улс хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн түвшнээр дэлхийн 185 орноос 151 дүгээрт, нас баралтаар 113 дугаар байранд эрэмбэлэгдэж байна. Нас баралтын эрэмбээр Ази номхон далайн баруун бүсийн орнуудаас бага, харин Зүүн Азийн орнуудаас өндөр байна.

2024 онд 0-19 насны 148 хүүхдийн хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэн бөгөөд хорт хавдрын шалтгааны улмаас 66 хүүхэд эндсэн байна. Хүүхдийн хорт хавдрын 45 хувийг цус, тунгалгийн хавдар, 18 хувийг тархи мэдрэлийн хавдар, 9 хувийг яс мөгөөрс, зөөлөн эдийн хавдар, 5 хувийг бөөрний хавдар, бусад хавдрууд үлдсэн хувийг тус тус эзэлж байна.

Хорт хавдрын өвчлөлийн хэтийн төлөв

Монгол Улсын хүн ам 1962 онд 1 сая байсан бол 2023 онд 3,5 сая болж 3.5 дахин нэмэгдсэн байна. 2050 он гэхэд хүн амын тоо 5 саяд хүрч тэр дундаа хорт хавдраар өвчлөх 60-аас дээш насны хүн амын тоо 2023 онтой харьцуулахад 3.5 дахин нэмэгдэх тооцоо байна. Өөрөөр хэлбэл хорт хавдраар өвдөх эрсдэлтэй хүн ам ялангуяа насжилт нэмэгдэхтэй холбоотой өсөх хандлагатай байна.

ДЭМБ-ын Хавдрын судалгааны агентлагаас хүн ам зүйн үзүүлэлтэд үндэслэж хийсэн тооцооллоор 2050 он гэхэд Монгол улсад хорт хавдрын шинэ тохиолдлын тоо 2,5 дахин нэмэгдэх урьдчилсан тооцоолол гарсан байна. Тухайлбал, улаан хоолойн хорт хавдар 3.3 дахин, уушгины хорт хавдар 2.8 дахин, элэгний хорт хавдар 2.6 дахин, ходоодны хорт хавдар 2.5 дахин, бүдүүн, шулуун гэдэсний хавдар 2.6 дахин, умайн хүзүүний хорт хавдар 1.8 дахин, хөхний хорт хавдар 1.7 дахин өсөх тооцоолол байна.

1.3 Хавдраас сэргийлэх, хянах дэлхий дахины бодлого

Дэлхий дахинаа хорт хавдрын өвчлөл, нас баралт эрс нэмэгдэж байгаа хэдий ч хавдрын өвчлөлийн 50-с багагүй хувийг урьдчилан сэргийлэх боломжтой хэмээн үзэж дэлхийн улс орнууд хавдраас сэргийлэх, хянах цогц бодлого хэрэгжүүлэхэд онцгой анхаарч байна.

Хорт хавдар нь 21-р зуунд хүн төрөлхтний хөгжилд төдийгүй дэлхий дахины эдийн засагт ч гол саад бэрхшээл учруулж буй хүчин зүйл хэмээн үзэж, Хорт хавдраас сэргийлэх, хянах чиглэлд НҮБ тэр дундаа ДЭМБ-аас дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- 2011 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн халдварт бус өвчний асуудлаарх дээд хэмжээний анхны уулзалтаас гишүүн орнуудад хандаж, улс төрийн тунхаглал гаргаж, амлалт авсан;

- 2012 онд ДЭМБ-аас “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах төлөвлөгөө 2013-2020”-г баталсан;
- 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар “Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-г баталж уг зорилгын 3.4-д хавдрын хяналтыг сайжруулах, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг нэмэгдүүлэхэд хүүхэд, ахмад настны асаргаа, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний хамралтыг нэмэгдүүлэх асуудлыг онцгойлон авч үзсэн байна.

ДЭМБ нь дэлхийн улс орнуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагаанд ахиц дэвшил гаргах зорилгоор хорт хавдартай тэмцэх дараах санаачилгыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Үүнд:

- Умайн хүзүүний хавдрын 100 000 эмэгтэйд ногдох шинэ тохиолдлын тоог 4-д хүргэх, ХПВ-ийн дархлаажуулалтын хамралтыг 90 хувьд хүргэх, эрт илрүүлгийн хамрагдалтыг 90 хувьд хүргэх зорилт бүхий “Умайн хүзүүний хорт хавдрыг устгах санаачилга – 2020 он”;
- 2030 он гэхэд хүүхдийн хавдрын амьдрах чадварыг 60 хувьд хүргэх, улмаар 1 сая хүүхдийн амь насыг аврах томоохон зорилго тавин “Хүүхдийн хорт хавдрын дэлхийн санаачилга – 2020”; Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах глобал платформыг 2021 онд санаачлан бага дунд орлоготой орнуудад хүүхдийн хавдрыг эмчлэх чанартай эмээр 5 жил хүртэл хугацаанд үнэ төлбөргүй хангах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- 2040 он хүртэл хөхний хорт хавдрын нас баралтыг жил бүр 2,5%-р бууруулах, 2,5 сая нас баралтаас сэргийлэх “Хөхний хорт хавдрын санаачилга – 2021” багтана.

1.4 Хавдраас сэргийлэх, хянах бодлого, хэрэгжилт манай улсад

Манай улс түүхэндээ хавдраас сэргийлэх, хянах чиглэлээр дараах бодлогын баримт бичгийг 1997 оноос эхлэн хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хэрэгжсэн хугацаа	Хөтөлбөрийн нэр	Баталсан тушаал, тогтоол
1997-2005	Хорт хавдартай тэмцэх үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 1997 оны 3-р сарын 26-ны өдрийн 80 дугаар тогтоол
2006-2013	Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2005 оны 246 дугаар тогтоол
2011-2021	Хорт хавдраас сэргийлэх, хянах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө	Эрүүл мэндийн дэд сайд, Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн Удирдах хорооны дарга 2011.05.26-ны өдөр баталснаар
2008-2013	Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2008 оны 201 дүгээр тушаал
2014-2015	“Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хоёр дахь хөтөлбөр	Засгийн газрын 2014 оны 34 дүгээр тогтоол
2014-2015	“Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх стратеги хөтөлбөр”	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 183 дугаар тушаал (Хүчингүй болсон)
2015-2020	Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2014 оны 412 дугаар тушаал (Хүчингүй болсон)

2017-2021	“Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2017 оны 289 дугаар тогтоол
2020-2024	Хүүхдийн хорт хавдрын хөтөлбөр	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/201 дугаар тушаал
2021-2024	“Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаал
2024-2029	Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах дэлхийн платформ	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/152 дугаар тушаал

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монголын мянганы сорилтын сан (ММСС)-ийн санхүүжилтээр 2009-2013 онд халдварт бус өвчин, түүний дотор зарим төрлийн хорт хавдраас¹ сэргийлэхэд чиглэсэн төсөл, 2020 оноос Австрийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн техник тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавх бэхжүүлэх төсөл ихээхэн дэмжлэг болсон байна. Тухайлбал, Австрийн Засгийн газрын дэмжлэгтэй төслийн хүрээнд шугаман хурдасгуур аппарат, 3 хэмжээст комформал туяа эмчилгээ, IMRT – эрчмийг тохируулах туяа эмчилгээ, VMAT – эзэлхүүнт нуман туяа эмчилгээ, SBRT – стереотактик биеийн туяа эмчилгээг тус тус нэвтрүүлсэн нь хорт хавдрын эмчилгээ, оношилгоонд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд ихээхэн чухал хөрөнгө оруулалт болсон. Түүнчлэн ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн болон Сэйнт Жүд хүүхдийн хавдрын судалгааны төв хамтран хүүхдийн хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах глобал платформ хөтөлбөрийн хүрээнд 2025 – 2029 онд хүүхдийн хорт хавдрын зайлшгүй шаардлагатай 35 нэрийн эмээр 5 жилийн турш үнэ төлбөргүй хангагдана.

Монгол Улсын Засгийн газраас сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд дээрх хөтөлбөр, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлснээр:

- Хорт хавдрын шалтгаант нас баралтыг 2019 онтой (13.8) харьцуулахад 2023 онд (12.8) 0,8 промилээр бууруулж чадсан;
- Хорт хавдрын хожуу үе шатандаа оношлогдсон хувь 2007 онд 78,3 байсан бол 2022 онд 67,7 болж буурсан;
- Хорт хавдраар оношлогдон, эмчилгээнд хамрагдан 5-с дээш жил амьдарч байгаа хувь 43,3 хувь болж нэмэгдсэн;
- Системийн хими болон бай эмчилгээ хийж байгаа эрүүл мэндийн байгууллага нэмэгдсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан.

Гэсэн хэдий ч хүн амын дундах архи, тамхины хэрэглээ өндөр, агаарын бохирдол, хоол хүнсний зохисгүй хэрэглээ, хотжилт, хөдөлгөөний дутагдал, таргалалт зэрэг нь хорт хавдраар өвчлөх эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Түүнчлэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавх хангалтгүй байгаагийн улмаас иргэд Хавдар судлалын үндэсний төвд хандан тусламж үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага нэмэгдэж, хавдрын тусламж үйлчилгээний хүлээгдэл буурахгүй байна.

¹Умайн хүзүү, хөхний хорт хавдар

Иймд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хорт хавдраас сэргийлэх, хянах чиглэлд иргэн, гэр бүл төдийгүй салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1 Алсын хараа:

Хүн амын дундах хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулж, Монгол хүний дундаж наслалтыг нэмэгдүүлэх.

2.2 Зорилго:

Хүн амын дундах хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

2.3 Зорилт:

Зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

1. хүн амын дунд хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг идэвхжүүлэх;
2. хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоог өргөжүүлэх;
3. хорт хавдрын оношилгоо, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
4. хорт хавдрын сэргээн засах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;
5. хорт хавдрын бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах, эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх;
6. хорт хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлж буй хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх.

Зорилтын хүрээнд зонхилон тохиолдож байгаа 7 төрлийн хорт хавдар тухайлбал, элэг, ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэс, уушги, хөх, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хянах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тусад нь бүлэг болгон авч үзсэн болно.

2.4 Хэрэгжүүлэх зарчим:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд “Иргэн төвтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд хүргэх” гол зарчим баримтална. Үүний тулд:

1. Дэлхий дахины Тогтвортой хөгжлийн зорилтын гол уриа “Хэнийг ч орхигдуулахгүй байх”,
2. ДЭМБ-аас улс орнуудад зөвлөмж болгож буй “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх” - Хүн оршин буй газраасаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээг санхүүгийн эрсдэл багатайгаар авах боломжийг өргөжүүлэх,
3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх,
4. Төрийн бус байгууллага, иргэний оролцоог хөхүүлэн дэмжих,
5. Удирдлага, зохион байгуулалтын хувьд нэгдмэл байж, салбар хоорондын хамтын ажиллагааг “хож-хож” зарчимд тулгуурлан хэрэгжүүлэх,
6. Олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх,
7. Санхүүжилтийн хувьд үр ашигтай, үр дүнтэй байх зэрэг болно.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ

3.1 Зорилт 1. Хүн амын дунд хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг идэвхжүүлэх.

Хүн амын дундах эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлж, түүнийг бууруулах оновчтой арга хэмжээг хэрэгжүүлснээр хорт хавдрын өвчлөлийн 50 хүртэлх хувийг урьдчилан сэргийлэх боломжтой хэмээн ДЭМБ-аас улс орнуудад зөвлөмж болгож байна.

2018 онд үндэсний хэмжээнд хийсэн Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн IV судалгаагаар өдөр бүр тогтмол тамхи татах, хоногт 5 нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэх, хөдөлгөөний хомсдолтой, илүүдэл жин ба таргалалттай, артерийн даралт ихсэх гэх мэт нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийн эрсдэлийг үнэлсэн байна. Тус үнэлгээгээр халдварт бус өвчний эрсдэлгүй хүн ам дөнгөж 3.9 хувь, харин гурав ба түүнээс олон эрсдэлт хүчин зүйлс хавсран илэрч, халдварт бус өвчнөөр өвдөх өндөр эрсдэлтэй хүн ам 22.7 хувьтай гарчээ.

Иймд хүн амын дунд хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг тандах, түүнийг бууруулах оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл амьдралын хэв маягийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хорт хавдраас сэргийлэх АНХДАГЧ урьдчилан сэргийлэлт ихээхэн чухал байх болно.

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ
1. Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах	1. Өрх, сумын эрүүл мэндийн төвд хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл бүхий иргэдийг тогтмол хянах
	2. Архи, тамхины хэрэглээ, таргалалт, хөдөлгөөний дутагдал зэрэг эрсдэлт хүчин зүйлийн талаарх мэдээлэл, сургалт сурталчилгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах
	3. Эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр бодлого боловсруулагч шийдвэр гаргагч нарт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах
	4. Эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох
2. Урьдчилан сэргийлэх боломжтой хорт хавдрын эсрэг хариу арга хэмжээг өргөжүүлэх	1. Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нэвтрүүлэх
	2. Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтад эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулах (эрүүл мэндийн ажилтан, анагаахад элсэж буй оюутан, цэрэг, цагдаа гэх мэт)
	3. Гепатитын В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтыг өргөжүүлэх

Хүлээгдэж буй үр дүн:

- Хүн амын дундах эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах эрх зүйн орчин сайжирна.
- Хорт хавдрын эрсдэл бүхий иргэдийн хяналт сайжирч өрх, сумын эрүүл мэндийн төвөөс хэрэгжүүлэх үйл ажиллагаа тогтмолжино.
- Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтад зорилтот бүлгийн хүн амын 90 хувь хамрагдсан байна.
- Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалтад зорилтот бүлгийн хүн амын 80-аас дээш хувийг хамруулсан байна.

3.2 Зорилт 2. Хорт хавдрын эрт илрүүлэгт зорилтот бүлгийн хүн амын 50-с доошгүй хувийг хамруулж, эрт оношилгоог өргөжүүлэх

Эрт илрүүлгийн хөтөлбөр нь зорилтот бүлгийн хүн амыг урьж ирүүлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах, бүрэн оношлох, эргэн дуудах, эмчлэх боломжийг бүрдүүлсэн, үргэлжилсэн үйл явц байх ёстой.

Эрт илрүүлэг гэдэг нь харьцангуй эрүүл хүн амын дунд энгийн, өвөрмөц, өртөг багатай шинжилгээний арга ашиглан хорт хавдрыг илрүүлэх тогтолцоо юм. Хорт хавдрыг эрт илрүүлснээр төгс эмчлэх боломжийг нэмэгдүүлж, хавдраар өвчилсөн иргэдийн амьдрах хугацааг уртасгах ач холбогдолтой.

Эрт оношилгоо нь хожуу үе шатанд оношлогдсон өвчтөнүүдийн эзлэх хувийг бууруулах зорилготой бөгөөд хөх, умайн хүзүү, бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрыг эрт илрүүлж төгс эмчлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Эрт илрүүлэг, эрт оношилгоог оновчтой хийж, хэрэгжүүлснээр хожуу шатанд оношлогдсон эмчлүүлэгчийн зардлын 61 хувийг хэмнэх боломжтой бөгөөд энэ хирээр улс орны нийгэм, эдийн засгийн байдалд эергээр нөлөөлдөг байна.

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ
1. Хорт хавдрын эрт илрүүлэг, эрт оношилгоог улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулах, эрт оношилгооны чадавхыг сайжруулах	1. Хорт хавдрын эрт илрүүлгийг зорилтот бүлгийн хүн амд нас, насанд нь тохирсон ангиллаар зохион байгуулж хэвших
	2. Эрт илрүүлэг оношилгоог орон нутагт бүсчилэн зохион байгуулах
	3. Эрт илрүүлэг, эрт оношилгооны чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах (техникч, дүрс оношилгооны эмч нарыг хавсруулан сургах)
	4. Иргэдэд чиглэсэн эрт илрүүлгийн ач холбогдол, зохион байгуулалтын талаар сургалт, мэдээлэл сурталчилгаа хийх
	5. Эрт оношилгоонд шаардлагатай урвалж, оношлуур, тоног төхөөрөмжөөр хангах
	6. Эрт илрүүлэг, эрт оношилгооны цахим мэдээллийн программ хангамжийг сайжруулах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх

Хүлээгдэж буй үр дүн:

- Зонхилон тохиолдох 7 төрлийн хорт хавдрын эрт илрүүлэг, эрт оношилгоо хийх тогтолцоо бүрэн бүрдэж, эрүүл мэндийн байгууллагуудын чадавх сайжирсан байна.
- Эрт илрүүлэгт зорилтот бүлгийн хүн амын 50-с доошгүй хувийг хамруулсан байна.
- Иргэд эрт илрүүлэг, эрт оношилгоонд хамрагдаж хэвшсэн байна.

3.3 Зорилт 3. Тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулан хорт хавдрын оношилгоо, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

Сүүлийн жилүүдэд хорт хавдрын оношилгоо, эмчилгээнд шинэ дэвшилтэт техник технологи өргөнөөр нэвтэрч, тусламж үйлчилгээний чанарт ахиц дэвшил гарч байна. Тухайлбал, ходоод, улаан хоолой, хөхний хорт хавдрын нөхөн сэргээх мэс засал, төвөнхийн бичил мэс засал, хэвлийн дурангаар элэгний сегмент тайрах мэс засал, хими эмчилгээнд хиймэл судас байрлуулах ажилбар, туяа эмчилгээнд шугаман хурдасгуур аппарат, 3 хэмжээст комформал туяа эмчилгээ, эрчмийг тохируулах туяа эмчилгээ, эзлэхүүнт нуман туяа эмчилгээ, стереотактик биеийн туяа эмчилгээ гэх мэт дэвшилтэт арга, технологиуд нэвтэрчээ. Ийнхүү тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтэрснээр 2018 онд хорт хавдар анх оношлогдсон тохиолдлын 67,1 хувь нь жил хүрэхгүй хугацаанд нас барж байсан бол энэ үзүүлэлт 2023 онд 66 хувь болж ялимгүй буурч, хожуу буюу III, IV шатандаа оношлогдсон хувь 78,3 хувиас 65,0 хувь болж буурсан үзүүлэлт гарсан.

Түүнчлэн хорт хавдар оношлогдож, хяналтад байгаа 5-с дээш жил амьдарч байгаа иргэд 2020 онд 39 хувийг эзэлж байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 43 хувь болж нэмэгдсэн байна.

Хорт хавдрын зарим тусламж, үйлчилгээ тухайлбал, 2007 онд хими болон бай эмчилгээг дан ганц ХСҮТ-д үзүүлж байсан бол 2023 оны байдлаар орон нутагт үзүүлэх боломж өргөжиж, системийн хими эмчилгээг улсын хэмжээнд 26 эрүүл мэндийн байгууллага (ХСҮТ, төв эмнэлэг-2, дүүргийн нэгдсэн эмнэлэг-5, аймгийн нэгдсэн эмнэлэг-13, хувийн хэвшлийн эмнэлэг-5), бай эмчилгээг 17 эрүүл мэндийн байгууллага (ХСҮТ, төв эмнэлэг-2, дүүргийн нэгдсэн эмнэлэг-3, аймгийн нэгдсэн эмнэлэг-6)-д үзүүлж байна.

Ийнхүү нэг талаас тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирч байгаа эерэг үзүүлэлт байгаа ч нөгөө талаас хорт хавдрын өвчлөл нэмэгдэж, хожуу шатандаа оношлогдох хувь дорвитой буулгүй ХСҮТ-д оношилгоо, мэс засал, сэргээн засах тусламж, үйлчилгээ авахаар хандаж байгаа иргэдийн тоо жилээс жилд нэмэгдэж, тусламж, үйлчилгээ төвлөрөн, амбулатори, мэс заслын тусламж, үйлчилгээний хүлээгдлийн тоо нэмэгдэж байна.

Иймд цаашид хорт хавдрын тусламж, үйлчилгээг өргөжүүлэх, энэ чиглэлээр хүний нөөцийн болон тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ
1. Оношилгоонд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх	1. Молекул генетикийн оношилгоог нэвтрүүлэх
	2. Хавдрын бай эмчилгээнд шаардлагатай мутацийн шинжилгээг өргөжүүлэх
	3. Удамшлын шалтгаантай хорт хавдрын илрүүлэг болон оношилгоонд генетикийн шинжилгээг нэвтрүүлэх
	4. Орон нутагт хийгдэж байгаа дүрс оношилгооны чадавхыг сайжруулах
	5. Эмгэг судлалын оношилгоонд шинэ технологи нэвтрүүлэх
2. Оношилгооны чанарын хяналтын цахим тогтолцоог бүрдүүлэх	1. Дүрс оношилгооны болон эмгэг судлалын шинжилгээний хариуг зайнаас цахимаар хянах, үнэлгээ өгөх үйл ажиллагааг нэвтрүүлэх
	2. Цахим эдийн банк үүсгэх
3. Эмчилгээнд үр дүнтэй, хөнөөл багатай мэс заслын эмчилгээний шинэ арга технологи нэвтрүүлэх	1. Хавдрын мэс заслын эмчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх
	2. Эрхтэн хадгалах мэс заслыг тусламж үйлчилгээнд өргөжүүлэх
	3. Хорт хавдрын нөхөн сэргээх мэс заслыг өргөжүүлэх
	4. Цацраг идэвхт бодисыг хорт хавдрын оношилгоо, эмчилгээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах
	5. Зонхилох байрлалын хорт хавдрын эмнэл зүйн стандарт, заавар, журмыг шинэчлэн боловсруулах
	6. Хорт хавдрын мэс заслын чиглэлээр хүний нөөцийн чадавх бэхжүүлэх
4. Хорт хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх	1. Аймаг, нийслэлд хорт хавдрын тусламж үйлчилгээ үзүүлэх бүсчлэл, тусламж үйлчилгээний төрлийг тодорхойлж, үйл ажиллагааг тогтмолжуулах
	2. Бүсийн аймагтай хамтран ажиллах хорт хавдрын эмч нарын баг бүрдүүлж эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн чадавхыг сайжруулах
5. Туяа эмчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хавдрын бусад эмчилгээний төрлүүдтэй хосолсон эмчилгээний цар хүрээг өргөтгөх	1. Туяа эмчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх (стереотактик туяаны мэс засал, 4 хэмжээст компьютер томографид суурилсан амьсгалын хөдөлгөөн зохицуулалттай туяа эмчилгээ, эд завсрын дотуур туяа эмчилгээ, бүтэн биеийн туяа эмчилгээ)
	2. Хавдрын бусад эмчилгээний төрлүүдтэй хосолсон эмчилгээний цар хүрээг өргөтгөх (неоадьювант туяа эмчилгээ, адаптив туяа эмчилгээ, хөнгөвчлөх туяа эмчилгээ)

	3. Цусны үндсэн болон туслах үйлдвэрийн гаралтай хавдартай үйлчлүүлэгчдийн туяа эмчилгээг дангаар болон хими, бай эмчилгээтэй хавсруулан хэрэглэж уртасгах
6. Системийн эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүртээмжийг сайжруулах	1. Хорт хавдрын хими эмчилгээнд орчин үеийн шинэ арга аргачлал нэвтрүүлэх
	2. Цусны үүдэл эс, чөмөг шилжүүлэн суулгах эмчилгээг нутагшуулах
	3. Мэс засал, туяа эмчилгээ хосолсон эмчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх
	4. Хими эмчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах
7. Хавдар судлалын үндэсний төвийн тусламж, үйлчилгээний чадавхыг сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлэх	1. Хавдар судлалын үндэсний төв-2 байгуулах төслийн бэтгэл ажлыг хангах

Хүлээгдэж буй үр дүн:

- Хорт хавдрын тусламж, үйлчилгээг төрөлжсөн хэлбэрээр олон мэргэжлийн багаар үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын чадавх бүрдсэн байна.
- Хорт хавдрын тусламж үйлчилгээнд оношилгоо, эмчилгээний шинэ техник технологи нэвтэрсэн байна.
- Хорт хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтний чадавх дээшилсэн байна.
- Хорт хавдрын тусламж, үйлчилгээний хүлээгдэл буурсан байна.

3.4 Зорилт 4. Хорт хавдрын үеийн сэргээн засах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Хорт хавдрын үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ нь хорт хавдартай иргэн нийгэмших үйл явцад чухал нөлөө үзүүлэхээс гадна хорт хавдрын онош тавигдаж, өвөрмөц эмчилгээ хийх явцад хавсран хэрэглэгдэх эмчилгээ юм. Хорт хавдрын сэргээн засах эмчилгээ нь хавдрын өвөрмөц эмчилгээний хүндрэл, гаж нөлөөнөөс сэргийлэх, бууруулахын зэрэгцээ хөдөлмөрийн чадварыг сэргээх, дахилтаас сэргийлэх ач холбогдолтой. Хорт хавдрын сэргээн засах эмчилгээнд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал төдийгүй физик эмчилгээний олон төрлийн арга технологийг хослуулан ашиглана.

Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг, өвдөлт намдаах хөнгөвчлөх эмчилгээ, асаргаа, сувилгаа, сургалт, нийгмийн халамж үйлчилгээ багтдаг.

Хорт хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээ нь хорт хавдрын хожуу шатанд болон эрт үедээ боловч өвөрмөц эмчилгээнд үр дүнгүй, эмчилгээний гаж нөлөө нь амин чухал эрхтний дутагдалд нөлөөлсөн хүнд өвчтөн түүний ар гэр, асран хамгаалагчдын амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бие махбодын, сэтгэл санааны, нийгмийн, сүсэг бишрэлийн цогц тусламж үйлчилгээ юм.

Манай улсад 2000 онд анх хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний тасгийг ХСҮТ-д 10 ортой, 2 эмч, 5 сувилагчтай нээж байсан бол өнөөгийн байдлаар бүх аймаг, дүүрэгт нийт 199 ор бүхий тасаг давхардсан тоогоор ажиллаж байна.

2022 оны байдлаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг үзүүлэхээр төрийн өмчит 39, хувийн хэвшлийн 6 эрүүл мэндийн байгууллага гэрээ байгуулан ажиллаж байна.

Хавдартай иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх Ногоон гэр төвийг 2019 онд ХСҮТ-ийн дэргэд байгуулсан. Тус төвд 2023 оны байдлаар хоол зүйч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан гэсэн 3 орон тоотойгоор жилдээ давхардсан тоогоор 3,000 гаруй иргэнд хооллолтын зөвлөгөө, 370 гаруй иргэнд сэтгэл зүйн оношилгоо ба засал, 1,600 гаруй иргэнд нийгмийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна.

Гэсэн хэдий ч хорт хавдартай иргэдэд үзүүлэх сэргээн засах тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй, энэ талаарх иргэдийн мэдээлэл хомс, хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хорт хавдартай иргэдийг бүрэн хамруулах асуудал тулгамдсан хэвээр байна.

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ
1. Хорт хавдартай иргэдэд үзүүлэх сэргээн засах тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх	1. Хими, туяа эмчилгээ, мэс заслын өмнө болон дараах сэргээн засах тусламж үйлчилгээг сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал ба физик эмчилгээг цогцоор нь үзүүлэх
2. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	1. Хөнгөвчлөх эмчилгээний хүний нөөцийн багаар ажиллах боломж, нөхцөлийг сайжруулах, чадавхжуулах (хөнгөвчлөх эмчилгээний эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэл заслын эмч гэх мэт)
	2. Хүүхдийн хорт хавдрын үеийн хөнгөвчлөх эмчилгээний хүртээмжийг сайжруулах
	3. Хүүхдийн хөнгөвчлөх эмчилгээнд эмийн бус аргыг өргөжүүлэх (урлаг, амьтан, ус, агаар, сарниулах арга, танин мэдэхүйн арга гэх мэт)
	4. Хорт хавдартай иргэдийн гэр бүлийн гишүүдэд сургалт, зөвлөгөө мэдээллийн арга хэмжээг өргөжүүлэх
	5. Хорт хавдрыг даван туулагчдийн хөтөлбөрийг өргөжүүлэх, дэмжих

Хүлээгдэж буй үр дүн: Хорт хавдартай эмчлүүлэгчид үзүүлэх сэргээн засах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоо нэмэгдэж, олон нийтэд түшиглэсэн тусламж үйлчилгээ өргөжсөн байна.

3.5 Зорилт 5. Хорт хавдрын бүртгэл, мэдээллийн тогтолцоог бүрэн цахимжуулж эрдэм, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх

Хорт хавдрын оношилгоо, эмчилгээнд олон шинэ арга, технологи нэвтэрч байгаа ба тус технологийг ашиглах, үнэлэх, шинэчлэх тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрт нотолгоонд тулгуурлан үр дүнгийн шинжилгээ хийх, өртгийг судлах,

цаашлаад эмчлүүлэгч болон түүний ар гэр, эрүүл мэндийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдыг нотолгоот мэдээллээр хангах судалгаа хомс байна.

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ
1. Хорт хавдрын бүртгэл мэдээлэл, тандалтын тогтолцоог сайжруулах	1. Хорт хавдрын үндэсний бүртгэлийн CanReg-Mon программыг олон улсын жишигт нийцүүлэх
	2. Хорт хавдрын бүртгэл, эрт илрүүлгийн бүртгэлийн хооронд бодит цагийн мэдээлэл, эргэх холбооны мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, дашбоард үүсгэх
	3. Хорт хавдрын бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн болон тоног төхөөрөмжийн чадавхыг сайжруулах
	4. Хорт хавдрын статистик мэдээ мэдээллийг түгээх төрөл, сувгийг нэмэгдүүлэх
2. Хорт хавдрын чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх	1. Зонхилон тохиолдох хорт хавдрын эдийн биобанкийг өргөжүүлэх
	2. Хорт хавдрын молекул генетикийн судалгааг өргөжүүлэх
	3. Молекул эпидемиологийн судалгааг хөгжүүлэх
	4. Эмнэлзүйн туршилт судалгааг хөгжүүлэх
	5. Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл, шалтгаан болон оношилгоо, эмчилгээний чиглэлээр үндэсний хэмжээнд хийгдсэн суурь судалгааны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх

Хүлээгдэж буй үр дүн:

- Хорт хавдрын бүртгэл, мэдээлэл бодит цагийн горимд бүрэн шилжин, эрүүл мэндийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох боломж бүрдэж мэдээллийн давхардал, хийдэл арилсан байна.
- Хорт хавдрын чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил өргөжнө.
- Нотолгоонд суурилсан шийдвэр гаргалт сайжирна.

3.6 Зорилт 6. Хорт хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлж буй хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх

Эрүүл мэндийн салбарт 2023 оны байдлаар нийт 66.3 мянган албан хаагчид ажиллаж байна. Сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад нийт албан хаагчдын тоо 11.8 мянгаар нэмэгдсэн байна.

2023 оны статистик мэдээллээр 10,000 хүн амд ногдох хавдрын эмч 0,3 байна (Энэтхэг 0,01, Турк 0,07, Солонгост 0.11, Хятадад 0,18, Польш 0.21, Орост 0.4, Японд 0.9, АНУ-д 1,6)².

Тэргүүлэх чиглэл	Хэрэгжүүлэх зорилтот арга хэмжээ
1. Хавдрын зарим нарийн мэргэшлээр эмч эмнэлгийн мэргэжилтэнг сургах	1. Шаардлагатай мэргэшлийн индексийг ажил мэргэжлийн жагсаалтад нэмж оруулах
	2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулах
	3. Гадаадын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг эх орондоо авчирч эмч эмнэлгийн мэргэжилтнийг дадлагажуулан сургах
	4. Анагаахын их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах
2. Хорт хавдрын чиглэлээр анхан шатны эрүүл мэндийн байгууллага, нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах	1. Дүүргийн болон аймгийн нэгдсэн эмнэлэгт хавдрын эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургах, чадавхжуулах
	2. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хавдрын эрт илрүүлэг, эрт оношилгооны чиглэлээр сургах, чадавхжуулах
	3. Хавдрын чиглэлээр төрийн бус байгууллага, олон нийтээс сургагч багш, зөвлөгч бэлтгэх

Хүлээгдэж буй үр дүн:

- Хорт хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн эмч нар бэлтгэгдэж, хүний нөөцийн чадавх сайжирсан байна.
- Орон нутагт хорт хавдрын тусламж, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдсэн байна.

² Statista 20246 Jenny Yang Now30.2023

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт



4.2 Хөтөлбөрийн санхүүжилт:

Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд:

1. Улсын болон орон нутгийн төсөв
2. Эрүүл мэндийн даатгалын сан
3. Эрүүл мэндийг дэмжих сан
4. Шинжлэх ухаан технологийн сан
5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр
6. хандивлагч улс орон, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж
7. Бусад эх үүсвэр

4.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хяналт- шинжилгээ үнэлгээ:

Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн тайлагналтыг ХСҮТ нэгтгэн жил бүр Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах хороонд танилцуулна. ЭМЯ-с явцын хяналт-шинжилгээг 2026 онд, хөтөлбөрийн төгсгөлийн үнэлгээг 2029 оны эхний улиралд багтаан хийж гүйцэтгэнэ.

Хяналт-шинжилгээ үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

ШҮ-ийн #	Шалгуур үзүүлэлт (ШҮ)	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин		Мэдээллийн эх сурвалж
			2026 он	2028 он	
1.	Зорилтот бүлгийн хүн амын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь		≥34.2	≥54.2	Эрүүл мэндийн статистик мэдээлэл
	Элэгний хорт хавдар		≥30	≥50	
	Ходоодны хорт хавдар		≥30	≥50	
	Улаан хоолойн хорт хавдар		≥30	≥50	
	Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар		≥30	≥50	
	Хөхний хорт хавдар		≥50	≥70	
	Умайн хүзүүний хорт хавдар	38.6%	≥50	≥70	
	Уушигны хорт хавдар		≥20	≥40	
2.	Хорт хавдрын мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх чадавх бүрдсэн аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тоо	-	6	8	ХСҮТ-ийн хавдрын бүртгэлийн тайлан
3.	Оношлогдсоноос хойш 5 ба түүнээс дээш жил амьдарсан хүний эзлэх хувь				ХСҮТ-ийн хавдрын бүртгэлийн тайлан
	Элэгний хорт хавдар	19.4	Суурь үзлэлтээс 5-аас доошгүй хувь нэмэгдсэн байна		
	Хөхний хорт хавдар	38.8	Суурь үзлэлтээс 8-аас доошгүй хувь нэмэгдсэн байна.		
	Умайн хүзүүний хорт хавдар	45.8	Суурь үзлэлтээс 8-аас доошгүй хувь нэмэгдсэн байна		
	Ходоодны хорт хавдар	27.3	Суурь үзүүлэлтээс 8-аас доошгүй хувиар өссөн байна		

ТАВ. ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ

5.1 ЭЛЭГНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ



Дуудах, бүртгэх, хянах

HBV/HCV ИЛРҮҮЛЭХ

Зорилтот хүн ам:

- 18-аас дээш насны хүн ам
- Гепатитын вирус тодорхойлж байгаагүй иргэдээс эхэлнэ

Илрүүлгийн арга:

- HBV/HCV илрүүлэх түргэвчилсэн сорил, ачаалал үзэх
- Цусанд АФП тодорхойлох
- ЦДШ, Биохими
- ЭХО

Өрх, сум, тосгон:


- Дуудах, бүртгэх, хянах
- HBV/HCV илрүүлэх түргэвчилсэн сорил

Аймаг, дүүрэгт:


- HBV/HCV ачаалал үзэх
- Цусанд АФП тодорхойлох
- ЦДШ, Биохими
- ЭХО

Хяналтын давтамж:

3-6 сар








5.5 УМАЙН ХҮЗҮҮНИЙ ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ЗУРАГЛАЛ





6.1. ХОРТ ХАВДРААС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ (2025-2028)

Хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүгийн эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				Төсөв (сая төгрөгөөр)				Төсөв (сая төгрөгөөр)	Хэрэгжүүлэгч байгууллага		
						2025 он	2026 он	2027 он	2028 он	2025 он	2026 он	2027 он	2028 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Нэг. Хүн амын дунд хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг идэвхжүүлэх																	
Зорилт 1.1. Өрх, сумын хүн амын дунд халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа хийх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад мэдээллийн сан, хяналтын тогтолцоог бүрдүүлэх	1	Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд иргэдийн дундах халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгааг үндэсний хэмжээнд хийх	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр	-	Хамрагдвал зохих зорилтот бүлгийн хүн амын дундах судалгаанд хамрагдсан иргэдийн хувь	50%	100%	-	-	30.0	20.0	-	-	50.0	НЭМУТ	Аймаг, Нийслэлийн ЗДТГ	Сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв
	2	Өрх, сумын эрүүл мэндийн төв айл, өрхүүдэд халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийн судалгаанд үндэслэн эрсдэлт бүлгийн хүн амыг хянах, хавдрын эрт илрүүлэгт дуудах ажлыг зохион байгуулах	Эрүүл мэндийн даатгалын сан	-	Зорилтот хүн амын хяналтын хувь, эрт илрүүлгийн хамрагдалтын хувь	25%	50%	70%	100%	-	-	-	-	-	Сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв	ЭМДЕГ, Аймаг, Нийслэлийн ЗДТГ	-
Зорилт 1.2. Эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах	1	Илүүдэл жин, таргалалтаас сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр	Илүүдэл жин, таргалалттай хүн амын хувь 49.4% (STEPS-2019)	Илүүдэл жин, таргалалттай хүн амын хувь	45%	40%	35%	30%	70.0	70.0	70.0	70.0	280.0	НЭМУТ	Аймаг, Нийслэлийн ЗДТГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
	2	Бүх төрлийн тамхины эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө болон дам тамхидалтын тархалтыг бууруулахад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны арга хэмжээ зохион байгуулах	Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр	15-69 насны хүн амын дундах тамхины хэрэглээ 24.2% (STEPS-2019)	Хүн амын дундах тамхины хэрэглээ	20%	18%	16%	14%	100.0	100.0	100.0	100.0	400.0	НЭМУТ	Аймаг, Нийслэлийн ЗДТГ	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
